



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 10 өдөр

Дугаар А/1644

Хэрлэн сум

Газар эзэмших эрх  
дуусгавар болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу 1 дүгээр хавсралтад дурдсан газруудын газар эзэмших эрхийг дуусгавар болгосугай.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2006 оны 122 дугаар захирамж, Хэрлэн сумын 1997 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн 92, 2012 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн А/258 дугаар захирамжийг тус тус хүчингүй болгосугай

3. Газар эзэмших эрхийг дуусгавар болгох тухай шийдвэрийн дагуу тус газруудыг нийтийн эзэмшилд шилжүүлж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Сүнгээ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ

Аймгийн Засаг даргын 2024 оны  
12 дугаар сарын 10-ны өдрийн  
116.41 дугаар захирамжийн хавсралт

Дуусгавар болж буй нэгж талбарууд

№	Хуулийн этгээдийн нэр	Нэгж талбарын дугаар	Газрын байршил	Газрын хэмжээ /м2/
1	АЗДТГазар	2311025056	4-р баг А-33-р байр	759
2	АЗДТГазар	2311027301	4-р баг Дсопын байр	481
3	АЗДТГазар	2311029909	4-р баг А-32-р байр	1107
4	АЗДТГазар	2311029878	4-р баг Навааннэрэнгийн гудамж Цагаан цахир уул ХХК-ийн зүүн залгаа	871
5	АЗДТГазар	2311029703	3-р баг Тээвэрчдийн гудамж хуучнаар Хүнсний үйлдвэр	1694